

Усалгаагвй нохцолд вр тарианы зарим нэг наст ургамлыг тэжээлд болон даршинд зориулан тариалах тохиромжтой хугацааг тогтоох зорилгоор 2006-2008 онд Архангай аймгийн Ихтамир (ондор уулын бvслvvp), Тос аймгийн Баянчандмань, Борнуурт (ойт хээрийн бvслvvp) хээрийн туршилт явууллаа..

Хээрийн судалгаанд хошуу будаа, хох тариа, судан овс, эрдэнэшиш, наранцэцэг, рапс, вандуй, шар буурцаг гэх 8 зvйл нэг наст ургамал хамрагдсан ба эдгээрийг 6-р сарын 5, 6-р сарын 15, 6-р сарын 25, 7-р сарын 5 гэсэн 4 оор хугацаанд тариалав.

Судалгааны явцад цухуйсан ургамлыг тоолж, ондрийг хэмжиж, хогжлийн ve шатыг ажиглаж тэмдэглэн цэцэглэлтийн ба вр боловсролтын эхэн вед ногоон ургацыг тодорхойллоо. Мөн тоон материалын статистик боловсруулалтыг SPSS 16.0 програмаар гvйцэтгэлээ.

Цаг уурын мэдээнээс vзэхэд ондор уулын бvслvvpт 2007, 2008 оны ургамал ургалтын хугацааны агаарын дундаж температур ОЖД-аас илvv байна. 2007 оны 6, 7-р саруудад агаарын дундаж температур ОЖД-аас 3.6-4.6°C-аар ондор, хур тундас бага байлаа. Харин 2008 онд ОЖД-аас 30 мм илvv хур тундастай байв.

Тарих хугацаанаас хамааран тэжээлийн нэг наст ургамлын цэцэглэх ба вр боловсорч эхлэх хугацаа оор байна. 2 жилийн дунджаар ойт хээрийн бvсийн усалгаагвй нохцолд рапс, вандуй, шар буурцагийг 6-р сарын 5-аас 7-р сарын 5 хvртэлх аль ч хугацаанд тарьсан цэцэглэх боломжтой нь харагдлаа. Харин хох тариаг 6-р сарын 25-аас, хошуу будааг 6-р сарын 15-аас хойш таривал 8-р сарын сvвлч 9-р сарын эхээр цэцэглэх боломжтой боловч намрын анхны хvйтгэлтэд ортож болзошгvй юм. Наранцэцэг, судан овс, эрдэнэшишийг 6-р сарын 5-аас 15-нд тариалбал 8-р сарын сvвлчээр цэцэглэх ба энэ вед ногоон тэжээлд ашиглах боломжтой байна.

6-р сарын 25-аас хойш тарихад ихэнх таримлуудын хувьд вр боловсрох хугацаа хязгаарлагдмал байлаа.

Ондор уулын бvслvvpт намрын анхны хvйтрэлт ихэвчлэн 8-р сарын сvвлчээр тохиодог учраас тэжээлийн нэг наст ургамлуудыг вр боловсролтын эхэн вед нь ашиглах боломжгvй байна (1-р хvснэгт).

1-р хvснэгт. Тарьсан хугацаанаас хамааран тэжээлийн нэг наст ургамлын цэцэглэх ба вр боловсорч эхлэх хугацаа

#	Зvйлийн нэр	цэцэглэлт	вр болов
5/VI	15/VI	25/VI	5/VII

Ойт хээрийн бvслvvp			
1	Рапс	15/VII	19/VII

2	Вандуй“Вега”	26/VII	3/VIII
3	Шар буурцаг	2/VIII	9/VIII
4	Хох тариа	5/VIII	13/VIII
5	Хошуу будаа	16/VIII	21/VIII
6	Наранцэцэг	16/VIII	23/VIII
7	Судан овс	17/VIII	24/VIII

8	Эрдэнэшиш	19/VIII	24/VIII
Ондор уулын бvслvvр 1	Рапс	10/VII	6/VIII
2	Хох тариа	31/VII	18/VIII
3	Хошуу будаа	3/VIII	12/VIII
4	Наранцэцэг	5/VIII	20/VIII

5	Судан овс	15/VIII	25/VIII
---	-----------	---------	---------

6	Эрдэнэшиш	16/VIII	26/VIII
---	-----------	---------	---------

{pdf}images/pdfbook/sowing date of annuals.MGL.pdf{/pdf}